



**“ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ” ТӨХК-ИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:

Захиалагч:

YAG-ын САГ-ын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер
Я.Самбууням
Утас: 261885

Аудитор
Н.Нямдаваа
Утас: 260512

Монгол Улсын Үндэсний
Аудитын Газар
Засгийн газрын IV байр, Бага
тойруу-6, Улаанбаатар-46, Монгол
улс
Вэб хуудас: www.audit.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч:

“Номгон Аудит” ХХК

Гүйцэтгэх захирал
Г.Саранчимэг
Гар утас: 89891034
Цахим хаяг:
nomgonaudit@yahoo.com

Аудитор
Л.Соёлмаа
Б.Давгабазар

Хаяг: Чингэлтэй дүүрэг, Жуулчны
гудамж, Тайваны төв, 409 тоот
Утас: 70100023

Аудитын тайлан

Хавсралт 1. Агуулга

Хавсралт 2. Аудитын гэрчилгээ

Хавсралт 3. Менежментийн захидал

Хавсралт 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	3
2.5	Дотоод хяналт	3
2.6	Байгууллагын орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
2.9.1	Үндсэн хөрөнгийн талаар	4
2.9.2	Урт хугацаат зээлийн талаар	4
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	5
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	5
3	Менежментийн захидал	6
3.1	Үндсэн хөрөнгийн талаар	7
3.2	Урт хугацаат зээлийн талаар	8
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	9
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	9
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	10
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	11
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12

ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ
СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Т.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайланг хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.



Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ

БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ний гүйцэтгэх захирал Т.Жаргалсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд компаний санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үлдэгдэл өртөггүй болсон үндсэн хөрөнгүүдийг дахин үнэлэх, “Эрчим хүчний төсөл”-ийн 3503-MOG дугаартай дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу үүссэн урт хугацаат зээлийг Сангийн яамтай тооцоо нийлж, зээлийн эргэн төлөлтөнд анхаарах гэсэн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өмнөд бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2018/2/СТА-ТӨҮГ аудит хийлээ.


Аудитыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Компанийн удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 26-наас 03 дугаар сарын



15-ны хооронд хийхээр төлөвлөн “Номгон Аудит” ХХК-ийн аудитор Г.Саранчимэг, Л.Соёлмаа, Б.Давгабазар нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 09-нд “Номгон Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“Номгон Аудит” ХХК нь аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 15-нд Өмнөд бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ийн удирдлагад гардуулна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН


Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь эрхэм зорилгоо “Дэвшилтэт технологийг нэвтрүүлэн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангаж, түгээсэн эрчим хүчийг борлуулж, хэрэглэгчээ дээдлэн ажиллана”, Монгол Улсын Эрчим хүчний тухай хуулийн 17 дугаар зүйлд “... эрчим хүчээр зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлөөр хуулийн этгээдэд цахилгаан дулаан үйлдвэрлэх, дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигчээс цахилгаан дулаан худалдан авах, цахилгаан импортлох, цахилгаан дулааныг хэрэглэгчид худалдах” гэж тус тус тодорхойлсон байдаг.

Дээрх зорилтуудыг хэрэгжүүлэн Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 1-д “Гүйцэтгэх удирдлага нь компанийн дүрэм болон төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна” гэж заасны дагуу гүйцэтгэх захирал удирдаж байна. ТӨХК-ийн дүрмийг Хувьцаа эзэмшигчдийн 2015 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 04 тоот тогтоолоор баталсан. Байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөг Монгол Улсын Эрчим Хүчний Сайдаар батлуулан ажиллаж байна.

Тус компани Өмнөговь аймгийн 14 сумдын нутаг дэвсгэрийг хамран тус бүр 35.кВ-ын 436 км, 15.кВ-ын 168.8 км, 10 кВ-ын 292 км, 0.4 кВ-ын 9127 км цахилгаан дамжуулах агаарын шугам, 224 ширхэг хувиарлах байгууламж, дэд станцын цахилгаан тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хариуцан ажиллаж байна. Мөн 6/10 кВ-н “Эрчим” дэд станцын диспетчер техникч нар 24 цаг, таван ээлжээр ажиллаж 35/10 кВ-н Далан, Жуулчин, Манлай, Ханбогд, Баян-Овоо, Хүрмэн 35/15 кВ-н Ноён дэд станцуудын техникч нарыг диспетчерийн удирдлагаар ханган ажиллаж байна.

2017 оны хөрөнгө оруулалтын ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэгдэж Гурвантэс сумын 35/10 кВ-ын дэд станцыг барьж ашиглалтанд оруулж, цахилгаан дамжуулах агаарын шугамын шинэчлэх угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Өмнөд бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ ТӨХК-ийн удирдлага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Эрчим хүчний тухай, Шилэн дансны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулиудын хүрээнд Монгол Улсын Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос олгосон 2014 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 48\2013 дугаар бүхий Цахилгаан түгээх, мөн өдрийн 49/2013 дугаар бүхий Цахилгаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.



2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс компанийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан 14 горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2014 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн А/30 дугаар тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, Эрчим хүчний сайдын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 46 тоот тушаалаар “Эрчим хүчний аж ахуйн нэгж байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн бодлого” гэсэн баримт бичгүүдийг тус тус мөрдөн ажиллаж байна.

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлын суурийг орчин нөхцөл шинж чанарын хувьд материаллаг шинжтэй зүйлс илрээгүй ба эрсдэл бага гэж үнэлсэн тул орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын орлогын нэг хувиар тооцов. Борлуулалтын орлого 8,501.0 сая төгрөг бөгөөд түүний нэг хувь 85.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа. /ТАБ-СТА-В-1/

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Компанийн дүрэмд зааснаар өмчлөгчийн хяналтыг компанийн дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ. Энэ нь материаллаг алдаа гаргахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2017 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн А/04 тоот тушаалаар дотоод аудитын нэгж байгуулагдан дотоод хяналт шалгалт хийх журам, боловсруулан батлуулж мөрдөж ажиллаж байна.

2.6 Байгууллагын орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Монгол Улсын Эрчим Хүчний Сайдын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 219 тоот тушаал болон 2017 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 394 тоот тушаалаар тодотгон баталсан зорилтот түвшинг хэрэгжүүлэн нийт тайлант хугацаанд 43.3 сая кВт, цаг цахилгаан эрчим хүчийг 4,928.9 сая төгрөгөөр худалдан авч, 37.8 сая кВт, цаг цахилгаан эрчим хүчийг 5,440.2 сая төгрөгөөр борлуулж нийт 8,501.1 сая төгрөгийн орлоготой, 7,777.1 сая төгрөгийн зардалтай, 652.6 сая төгрөгийн цэвэр

ашигтай ажилласан байна. Дээрх үзүүлэлтийг урьд оны мөн үетэй харьцуулахад хэрэглэгчийн тоо 6.8 % нэмэгдэж, техникийн болон зүй бусын алдагдал 2.0 % буурч, борлуулалт 9.96 %, түгээлт 7.86% нэмэгдсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангасан талаар тодорхой тусгасан. Шилэн дансны мэдээллийг цахим хуудсаар байршуулсан бөгөөд <http://shilendans.gov.mn/org/5203> хаягаар дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу тохиолдох магадлалтай уламжлалт эрсдэлтэй 6, хяналтын эрсдэлтэй 4, санхүүгийн тайлангийн шинжилгээгээр өндөр эрсдэлтэй 4 санхүүгийн үзүүлэлтийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд санхүүгийн тайлангийн үзүүлэлт тус бүрээр 14 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Үндсэн хөрөнгийн талаар

Тайлант хугацаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн 40 нэрийн 257.1 сая төгрөгийн анхны өртөгтэй үндсэн хөрөнгө “0” үлдэгдэлтэй болсон байна.

Энэ нь НББОУС 16(40)-д “Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг бодит үнэ цэнэ нь мэдэгдэхүйц өөрчлөгдвөл өөрчлөгдсөн даруйд дахин үнэлэх” гэж заасныг зөрчсөн байна.


Шийдвэрлэсэн нь: НББОУС 16(40)-д “Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг бодит үнэ цэнэ нь мэдэгдэхүйц өөрчлөгдвөл өөрчлөгдсөн даруйд дахин үнэлэх” гэж заасныг мөрдөж ажиллах, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг хийх зөвлөмж өгөх;

2.9.2 Урт хугацаат зээлийн талаар

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн эхлэлтийн тайланд “Эрчим хүчний төсөл”-ийн 3503 – МОГ дугаартай дамжуулан зээлдүүлэх гэрээний 929.7 сая төгрөгийн урт хугацаат зээл Даланзадгад дулааны станц ТӨХК-аас шилжиж ирсэн. Хоёр байгууллагын тооцоо нийлсэн актаар 242.8 сая төгрөгийг “ДэДЦС” ТӨХК хариуцах, “ӨБЦТС” ТӨХК 686.9 сая төгрөгийн зээлийг хариуцахаар баталгаажуулсан байна. Мөн Сангийн яамны Санхүүгийн бодлогын газрын өрийн удирдлагын хэлтэстэй тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна. Гэтэл урт хугацаат зээлийн гэрээг Сангийн яамтай байгуулах талаар 2013 оноос хойш албан бичиг илгээсэн боловч хариу шийдвэр ирээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.16 “Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана” гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн яамтай урт хугацаат зээлийн гэрээг байгуулан, зээлийн эргэн төлөлтөнд анхааран ажиллах зөвлөж өгөх;



2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 944.0 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж зөвлөмж өгсөн.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2016 оны санхүүгийн тайланд “Голден пэйж аудит” ХХК-иас аудит хийсэн бөгөөд аудитаар 7 зөвлөмж өгснөөс 6 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмж (Урт хугацаат зээлийн гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэх) зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

Материаллаг байдлын түвшингийн суурийг тус байгууллагын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 1 хувиар тооцож 85.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргаж байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан болон Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн санхүүгийн тайлан, илтгэх хуудсыг тус тус хавсаргав.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Аудитын ажил гүйцэтгэх гэрээгээр Номгон аудит ХХК-ийн илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захиралд зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал, дүгнэлт гаргахад зориулагдсан. Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Бидний энэхүү зөвлөмж та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн удирдлага, санхүү, бүртгэлийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Үндсэн хөрөнгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
------------------------------------	----------------------------------

Ажиглалт

Үндсэн хөрөнгийн анхны өртгийн нийт дүн 15,500,267.3 мянган төгрөг бөгөөд үүнээс 257,130.8 мянган төгрөгийн анхны өртөг бүхий 40 нэр төрлийн үндсэн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн ч үндсэн зориулалтаараа ашиглагдаж үр өгөөжөө өгч байна. Эдгээр хөрөнгийг дахин үнэлүүлээгүй, санхүүгийн тайланд үлдэгдэл өртөггүйгээр тайлагнасан байна.

Энэ нь НББОУС 16.40 “Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг бодит үнэ цэнэ нь мэдэгдэхүйц өөрчлөгдвөл өөрчлөгдсөн даруйд дахин үнэлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

1. Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх
2. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй байх

Зөвлөмж

НББОУС 16.40 “Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээг бодит үнэ цэнэ нь мэдэгдэхүйц өөрчлөгдвөл өөрчлөгдсөн даруйд дахин үнэлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 01-ний дотор санхүүгийн аудитын газар ирүүлнэ үү.

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.



3.2 УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛИЙН ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №2
<p><u>Ажиглалт</u></p> <p>“Эрчим хүчний төсөл”-ийн 3503-МОГ дугаартай дамжуулан зээлдүүлэх гэрээний 929,696,386.51 төгрөгийн зээлийг “ӨБЦТС” ТӨХК-ийн 2013 оны эхлэлтийн балансанд тусгасан. 2015 онд уг зээлийн 242,813,765 төгрөгийг “ДзДЦС” ТӨХК хариуцахаар хоёр байгууллага тооцоо нийлж “ӨБЦТС” ТӨХК тайландаа 686,882,621,51 төгрөгийг урт хугацаат зээлийн өглөгөөр бүртгэснийг Сангийн яам болон ӨБЦТС ТӨХК-ийн хооронд урт хугацаат зээлийн гэрээг байгуулаагүй байна.</p> <p>Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.16-д “Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана” гэсэн заалттай нийцэхгүй байна.</p>	<p><u>Зөвлөмж</u></p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.16-д “Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана” гэсэн заалтийг хэрэгжүүлж ажиллах, Сангийн яамтай урт хугацаат зээлийн гэрээг байгуулан, зээлийн эргэн төлөлтөнд анхааран ажиллах.</p> <p>Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 6 дугаар сарын 01-ний дотор санхүүгийн аудитын газар ирүүлнэ үү.</p>
<p><u>Эрсдэл</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх 2. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлээгүй байх 	<p><u>Үйлчлүүлэгчийн хариу</u></p> <p>2018 оны эхний хагас жилд багтан гэрээ хийх асуудлыг шийдвэрлүүлнэ.</p>



4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	569,139,443.60	976,809,138.99
1.1.2	Дансны авлага	61,861,649.38	31,546,509.34
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	10,136,238.38	18,878,776.11
1.1.4	Бусад авлага	0.00	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	161,706,995.39	100,764,543.62
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,946,544.68	9,333,519.91
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	31,709,681.78
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	811,790,871.43	1,169,042,169.74
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	14,241,937,228.82	15,500,267,289.68
1.2.2	Биет бус хөрөнгө	7,955,383.38	6,528,841.74
1.2.3	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.4	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,249,892,612.20	15,506,796,131.41
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,061,683,483.63	16,675,838,301.16
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	6,899,397.77	2,341,994.03
2.1.1.2	Цалингийн өглөг	18,415.38	0.00
2.1.1.3	Татварын өр	29.30	6,718,527.21
2.1.1.4	Урьдчилж орсон орлого	37,605,781.00	21,102,581.00
2.1.1.5	Бусад богино хугацаат өр төлбөр	6,776,643.00	50,874,504.66
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	51,300,266.46	81,037,606.91
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	686,882,621.51	686,882,621.51
2.1.2.2	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	686,882,621.51	686,882,621.51
2.2	Өр төлбөрийн нийт дүн	738,182,887.97	767,920,228.42
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	14,240,798,494.53	15,239,713,592.68
2.3.2	- хувийн	0.00	0.00
2.3.3	- хувьцаат	0.00	0.00
2.3.4	Эздийн өмчийн бусад хэсэг	370,127,983.39	330,474,655.39
2.3.5	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(287,425,882.27)	337,729,824.67
2.3.11	Эздийн өмчийн дүн	14,323,500,595.65	15,907,918,072.74
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	15,061,683,483.63	16,675,838,301.16

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Үлдэгдэл	
		2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,833,549,346.36	8,227,580,862.72
2	Борлуулалтын өртөг	3,903,718,501.56	6,703,871,110.94
3	Нийт ашиг (алдагдал)	929,830,844.80	1,523,709,751.78
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	26,632,226.07	76,701,993.88
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	161,519,618.27	196,764,327.16
9	Борлуулалт, маркетингийн зардал	5,743,087.73	5,600,034.55
10	Ерөнхий ба удирдлагын зардал	951,053,548.68	985,586,030.03
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	3,515,497.05
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	(61,206,476.32)	(77,863,192.36)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	99,979,576.42	724,611,318.83
19	Орлогын татварын зардал	9,997,957.64	72,461,131.88
20	Татварын дараах ашиг (алдагдал)	89,981,618.78	652,150,186.94
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	89,981,618.78	652,150,186.94
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	89,981,618.78	652,150,186.94
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА


ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
1	2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	6,956,718,528.54	0.00	0.00	0.00	0.00	7,624,134,091.39	(373,980,501.04)	14,206,872,118.89
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	6,956,718,528.54	0.00	0.00	0.00	0.00	7,624,134,091.39	(373,980,501.04)	14,206,872,118.89
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	89,981,618.78	89,981,618.78
5	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
6	Өмчид гарсан өөрчлөлт	7,284,079,965.99	0.00	0.00	0.00	0.00	(7,254,006,108.00)	0.00	30,073,857.99
7	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(3,427,000.00)	(3,427,000.00)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	14,240,798,494.53	0.00	0.00	0.00	0.00	370,127,983.39	(287,425,882.27)	14,323,500,595.65
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	14,240,798,494.53	0.00	0.00	0.00	0.00	370,127,983.39	(287,425,882.27)	14,323,500,595.65
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	652,150,186.94	652,150,186.94
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	998,915,098.15	0.00	0.00	0.00	0.00	(39,653,328.00)	0.00	959,261,770.15
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	(26,994,480.00)	(26,994,480.00)
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	15,239,713,592.68	0.00	0.00	0.00	0.00	330,474,655.89	(337,729,824.67)	15,907,918,072.74




4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,651,667,632.51	6,523,459,992.91
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	5,562,902,828.74	6,181,575,909.09
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	113,636.36	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	88,651,167.40	341,884,083.82
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,368,993,330.06	5,402,021,747.93
1.2.1	Ажиллагчдад төлсөн	1,203,131,138.91	1,207,018,384.08
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	284,400,000.00	308,420,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,029,830,796.88	2,672,593,644.28
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	20,099,307.63	17,969,399.59
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	72,207,665.00	67,229,641.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	374,276,931.00	517,943,041.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	3,386,540.00	7,392,760.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	381,660,950.64	603,454,877.97
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	282,674,302.45	1,121,438,244.98
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	29,595,196.07	77,549,288.88
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	2,962,970.00	847,295.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	26,632,226.07	76,701,993.88
2.1.7	Хүлээн авсан ноогдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	81,158,642.18	764,323,358.45
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	79,673,642.18	764,323,358.45
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,485,000.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж	0.00	0.00



	эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(51,563,446.11)	(686,774,069.57)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,427,000.00	26,994,480.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	3,427,000.00	26,994,480.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,427,000.00)	(26,994,480.00)
4.1	Валютын ханшийн зөрүү	0.00	0.00
4.2	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	227,683,856.34	407,669,695.41
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	341,455,587.26	569,139,443.60
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	569,139,443.60	976,809,138.99



